

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2020, 2021 онд шаардлагатай өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл**  
Тендер шалгаруулалтын дугаар: **ТХААГ/202006009**

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар** эрх бүхий тендерт оролцогчдоос Ерөнхий гэрээгээр **Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2020, 2021 онд шаардлагатай өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл** нийлүүлэх тендер ирүүлэхийг урьж байна. Уг төсөл арга хэмжээ нь дараах багцаас бүрдэнэ.

Үүнд: **Багцын мэдээллийг ТШӨХ-ийн ТӨӨЗ 1.3-с харах**

Тендерийн баримт бичгийг цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс үнэ төлбөргүй татан авч, танилцаж болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй нийт багцын тооцоолсон төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

**Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй нийт багцын тооцоолсон төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн [www.e-balance.mof.gov.mn](http://www.e-balance.mof.gov.mn) мэдээллийн систем дэх тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.**

Ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын ижил төстэй ажлын өртгийн дундаж нь санал болгож буй нийт багцын төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх ба гэрээний хуулбар, захиалагчийн тодорхойлолтын хамт ирүүлэх**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байна.**

Тендерийг **2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 13 цаг 30 минутаас** өмнө Худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д цахим хэлбэрээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан доорх хаягт тендерийг **2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 14 цаг 00 минутад** нээнэ.

Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтын арга: **“үнийн санал авах”**

Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаа: **1 жил 6 сар хүртэл**

Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд шинээр Ерөнхий гэрээ байгуулах хүсэлтэй нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь тендер шалгаруулалтын шаардлагыг хангасан тохиодолд ерөнхий гэрээ байгуулж болно.

Гадаадын этгээд тендер ирүүлэх: **Эрхтэй.**

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо,  
Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр, 204 тоот  
Утас: 263014, 267023**

**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**